

8X100.MN


ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

өөрийгөө бэлтгэх математикийн тестүүд


Тус сайт нь 8x100 өөрийгөө бэлтгэх математикийн тестүүд 2 номын хэрэглэгч танд өөрийгөө болон сурагчдын амжилт, чанарын тухай дэлгэрэнгүй мэдээллийг автоматаар тооцуулан, статистик дүгнэлт гаргах боломжийг олгоно. Хэрэглэгчид багш болон сурагч гэсэн хоёр сонголтоор тус сайтыг ашиглана.


ШАЛГАХ

Та номон дээр ажилласан хариултын хэсгээ шалгаж, дүнгээ харахын тулд тэмдэглэгдсэн хэсэг дээр дарна.



Гарч ирсэн цонхны зүүн дээд буланд тухайн тестийн дугаарыг СОНГОНО.





8x100 өөрийгөө бэлтгэх математикийн тестүүд 2

СЭЛҮҮН САНАА ХХК

seluunsanaa@gmail.com

99010630, 91180910, 99177329

www.8x100.mn

Интер Номын их дэлгүүр

Улсын их дэлгүүр номын тасаг

Тестээ сонгосны дараа ажилласан тестийнхээ хариултыг хуулан тааруулна. Бөглөж дууссаны дараа БОДОХ товчийг дарна.

3. $\frac{1}{x+2} - \frac{1}{x-2} = 1$ тэгшитгэлийг бод. A. $3 + \sqrt{5}$ B. $3 \pm \sqrt{5}$ C. $-3 + \sqrt{5}$ D. $-3 - \sqrt{5}$ E. $3 - \sqrt{5}$

4. $\frac{4-y}{5} - 5y \geq 0$ тэнцэтгэл бишийг бод. A. $(-\infty; \frac{2}{13}]$ B. $(-\infty; \frac{1}{26}]$ C. $(-\infty; \frac{2}{13}]$ D. $(-\infty; \frac{1}{26}]$ E. $[\frac{2}{13}; \infty[$

5. $\{c_n\}$ нь арифметик прогресс бөгөөд $c_1 = 20$, $d = 3$ бол c_5 -ийг ол. A. 29 B. 32 C. 35 D. 38 E. 41

6. $2 \cos 0^\circ - 4 \sin 90^\circ + 5 \tan 180^\circ$ утгыг ол. A. 0 B. 1 C. -1 D. 4 E. -2

7. $\arcsin 0 + \arccos 0$ хэлтэй тэнцүү вэ? A. π B. 2π C. $\frac{\pi}{2}$ D. $\frac{\pi}{3}$ E. $\frac{\pi}{4}$

8. $x^2 + px - 35 = 0$ тэгшитгэлийн нэг шийд нь 7 бол нөгөө шийдийг ол. A. 5 B. -7 C. 7 D. -5 E. 3

9. $\begin{cases} 0.4x - 1 \leq 0 \\ 2.3x \geq 4.6 \end{cases}$ тэнцэтгэл бишийн системийн шийдийн олонлог аль вэ? A. $[-2; 2.5]$ B. $] -2; 2.5]$ C. $[-2.5; 2]$ D. $[-2.5; -2]$ E. $[2; 2.5]$

10. $\sin\left(-\frac{x}{3}\right) = \frac{\sqrt{2}}{2}$ тэгшитгэлийг бод. ($k \in \mathbb{Z}$). A. $(-1)^{k+1} \frac{\pi}{4} + 3\pi k$ B. $(-1)^k \frac{3\pi}{4} + 3\pi k$ C. $(-1)^{k+1} \frac{\pi}{4} + 2\pi k$

Ингэснээр таны ажилласан тестийн алдаа, оноо болоод дүн, хувь, өнгөрсөн оны байдлаар ЕШ-д авч болох байсан оноог харуулна.

Бүртгүүлсэн тохиолдолд энэхүү дүн таны нэр дээр үүссэн өгөгдлийн санд хадгалан үлдэх бөгөөд статистик хэсгээс өсөлт бууралтаа хянах боломжийг олгоно. Жич. Багш та бүртгүүлснээр өөрийн ангийн сурагчдын шалгалтанд анализ хийж, хүснэгт хэлбэрээр харах ба хэвлэн авах боломжтой болно. Дэлгэнгүй мэдээллийн доор Статистик хэсэгт тайлбарлагдана.

Бүртгүүлснээр статистик мэдээллийг харах, онлайн тест ажиллах, хэлэлцүүлэгт оролцох, зөвлөмж заавар авах гэх мэт олон давуу талуудыг эдлэнэ.

Бүртгүүлэхдээ зурагт үзүүлснээр дугуйлсан хэсэгт хандана.

www.8x100.mn

И-мэйл: Нууц үг:

Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлдэж буй мянга мянган сурагчдын гарын авлага болгох зорилгоор А, Б хувилбар бүхий 70 тестийг эмхэтгэн гаргав.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги нэг хичээлийн жилд 35 долоо хоног хичээлэдэг бөгөөд 7 хоног бүр 1 тестийг А, Б хувилбараар нь ажиллаж, жилийн турш өөрийгөө сорин бэлтгэх боломжийг энэхүү ном танд олгоно гэдэгт итгэлтэй байна.

Бүх тестийн хариу энэхүү цахим хуудсанд нийтлэгдсэн бөгөөд энэ нь тест бүрийг бүрэн ажиллаж дууссаны дараа өөрийгөө дүгнэн, хувилах боломжийг бүрдүүлнэ. Дээрх сайтад та өөрийн бодсон тестийн хариуг бөглөж, хэдэн хувийн гүйцэтгэлтэй байгаагаа тодорхойлж болохоос гадна, бүртгүүлсэн тохиолдолд жилийн турш өөрийн ахиц, түвшингийн өөрчлөлтийн статистик мэдээллийг графикаар харах боломжтой болох юм.

Энэхүү номыг математикийн сургалтаар улсдаа тэргүүлэх сургуулиудын багш нар хамтран гадаад эх сурвалж болон Б. Энхболд, Ч. Баасанжав – Математикийн тестүүд, 2005; А. Мекей, Л. Өвгөн, Р. Гончигдорж, П. Энхболд - Их дээд сургуульд элсэгчдэд тусламж – Математик, 1984 номууд; олон арван шавь нарын нэр их хөдөлмөрийн үр шимээр бүтээсэн бөгөөд цоо шинэ тестүүдээс бүрдсэн гэдгийг тодотгоход таатай байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтандаа 100 хувь гүйцэтгэлтэйгээр 800 оноо авах алтан боломж сурагч бүрд бий гэдгийг хэлэхийн сацуу, ажил амьдралын анхны томоохон сорилтоо сэтгэл дүүрэн өгөхийг нийт төгсөгчиддөө хүсье.

Шинээр бүртгүүлэх хэрэглэгч БҮРТГҮҮЛЭХ БОЛ гэсэн бичгийг дарна.

Бүртгүүлсэн хэрэглэгч нэвтрэх хэсэгт мэйл хаяг болон нууц үгийг оруулаад шууд нэвтэрч болно. Нууц үгээ мартсан болон идэвхижүүлэх код авах тохиолдолд доор байх 2 линкийг ашиглана.

www.8x100.mn

И-мэйл: Нууц үг:

Нэвтрэх

И-мэйл

Нууц үг

[Бүртгүүлэх бол](#)

[Нууц үгээ мартсан бол](#)

[Идэвхижүүлэх код дахин авах бол](#)

БҮРТГҮҮЛЭХ БОЛ товчийг дарснаар дараах цонх гарна. Овог, нэр, сургууль, анги хэсгийг бөглөсний дараа хэрэв сурагч бол СУРАГЧ, хэрэв багш бол БАГШ гэсэн сонголтыг сонгоно. Өөрийн ашигладаг и-мэйл хаягийг хоёр удаа оруулна. Тус и-мэйл хаягаар идэвхижүүлэх код очих тул үнэн зөв бөглөх хэрэгтэй. Дараа нь мартахгүй байдлыг бодолцож нууц үгээ 2 давтан оруулна.

И-мэйл: Нууц үг:

Бүртгүүлэх

Овог:

Нэр:

Сургууль:

Анги:


Сурагч эсэх:

И-мэйл:



Нууц үг:

Нууц үг давтах:

Бүх хэсгийг үнэн зөв бөглөсний дараа БҮРТГЭХ товчийг дарснаар таны бүртгүүлсэн и-мэйл хаягаар идэвхижүүлэх код илгээгдэнэ. Иймд та мэйл хаягаа шалгах хэрэгтэй.



Идэвхижүүлэх код Inbox-д дээрх байдлаар ирнэ. Анхаар: Зарим тохиолдолд Spam-д ирдэг. Ирсэн мэйл-рүү орж үргэлжлүүлэх товч дарснаар та амжилттай бүргэгдэх болно.



СТАТИСТИК



Энэ товч нь бүртгэлтэй хэрэглэгч танд таны бөгсөн тестүүдийн тухай мэдээллийг статистик байдлаар харуулна.

Сурагчдын хувьд ажилласан тест бүрийн үр дүн таны нэр дээр үүсэн өгөгдлийн санд хадгалагдсан байдаг ба статистик товчийг дарснаар таны авсан оноонууд графикаар харагдана.

Багшийн хувьд таны оруулсан ангийн шалгалтын дүнгийн хуудас хүснэгт хэлбэрээр гарах бөгөөд бодлого тус бүрийн гүйцэтгэл, амжилт, чанарын үзүүлэлтүүд харагдана. Үүнийгээ хэвлэж авах боломжтой.

ОНЛАЙН ТЕСТ



Энэ хэсэгт 8x100 өөрийгөө бэлтгэх математикийн тестүүд 2 номын танилцуулга болох хоёр тест байрлах бөгөөд сонирхсон хэрэглэгч бүр үнэ төлбөргүй ашиглаж болно.

Цаашдаа тус хэсгийг улам өргөжүүлэн онлайн тестийн уралдаан зохион байгуулахаар ажиллаж байна.

ХАРИУ – KEY



Бүх тестийн хариу энд байрлана. Хэрэглэгчдийн хүсэлтийг харгалзан чөлөөтэй харах боломжтой байх эсэхийг шийднэ.

ЗӨВЛӨМЖ



8x100 өөрийгөө бэлтгэх математикийн тестүүд 2 номын хүндэвтэр болоод хүсэлт хүлээн авч буй бодлогуудын бодолтын тухай зөвлөмжүүд, бодолтын арга замуудыг энд оруулна.

FORUM – ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



8x100 өөрийгөө бэлтгэх математикийн тестүүд 2 номын бодлого болоод тестүүдийн тухай хэлэлцүүлэг, маргаан, зөвлөлгөөн явуулах боломжийн энд олгоно.



Элсэлтийн ерөнхий шалгалтандаа 100 хувь гүйцэтгэлтэйгээр 800 оноо авах алтан боломж сурагч бүрд бий гэдгийг хэлэхийн сацуу, ажил амьдралын анхны томоохон сорилтоо сэтгэл дүүрэн өгөхийг нийт төгсөгчиддөө хүсье.



АГУУЛГА

ШАЛГАХ.....	1
БҮРТГҮҮЛЭХ.....	3
СТАТИСТИК.....	5
ОНЛАЙН ТЕСТ.....	5
ХАРИУ – KEY.....	5
ЗӨВЛӨМЖ.....	5
FORUM – ХЭЛЭЛЦҮҮЛЭГ.....	5